



БИО-АНАГААХ СУДЛААЧ

АХЛАХ зэрэг горилогч эмнэлгийн мэргэжилтэн нь дараах тусгай шаардлагыг хангасан байна. Үүнд:

1. Лабораторийн оношилгооны чиглэлээр 8-аас доошгүй жил тасралтгүй тусламж үзүүлсэн туршлагатай байх /нийгмийн даатгалын бичилтээр баталгаажсан байна/;
2. Сүүлийн 5 жилийн ажлын тайлан /удирдах ажилтны тамга, гарын үсгээр баталгаажсан байна/;
3. Жилд мэргэжлийн 6-аас доошгүй кредитийн сургалтанд хамрагдсан байх /гэрчилгээ, тодорхойлолтоор баталгаажсан байна/;
4. Сүүлийн 5 жилд тухайн лабораторид 3-аас доошгүй шинэ арга технологи, ашигтай загвар нэвтрүүлсэн байх /гэрчилгээ, тодорхойлолтоор баталгаажсан байна/;
5. Тухайн лабораторид био-анагаах судлаач, техникч нарт жилд 5-аас доошгүй удаа хичээл заасан байх /сургалтын материал, эмнэлгийн сургалтын албаар баталгаажсан байна/;
6. Мэргэжлийн англи хэлний зохих түвшингийн мэдлэгтэй байх /гэрчилгээгээр баталгаажсан байна/;
7. Компьютерийн мэдлэгийн зохих түвшин хангасан /гэрчилгээгээр баталгаажсан байна/;
8. Сүүлийн 5 жилд өгүүлэл, илтгэлийн 4-өөс доошгүй хураангуй нийтлүүлсэн байх /өгүүлэл, илтгэлийн хураангуйн хуулбараар баталгаажсан байна/.

ТЭРГҮҮЛЭХ зэрэг горилогч эмнэлгийн мэргэжилтэн нь дараах тусгай шаардлагыг хангасан байна. Үүнд:

1. Лабораторийн оношилгооны чиглэлээр 13-аас доошгүй жил тасралтгүй тусламж үзүүлсэн туршлагатай байх /нийгмийн даатгалын бичилтээр баталгаажсан байна/;
2. Ахлах зэрэг хамгаалаад 5 жил тасралтгүй ажилласан байх /мэргэшлийн зэргийн үнэмлэхийн эх хувиар баиалгаажсан байна/;
3. Сүүлийн 5 жилийн ажлын тайлан /удирдах ажилтны тамга, гарын үсгээр баталгаажсан байна/;
4. Жилд мэргэжлийн 6-аас доошгүй кредитийн сургалтанд хамрагдсан байх /гэрчилгээ, тодорхойлолтоор баталгаажсан байна/;
5. Сүүлийн 5 жилд тухайн лабораторид 3-аас доошгүй шинэ арга технологи, ашигтай загвар нэвтрүүлсэн байх /гэрчилгээ, тодорхойлолтоор баталгаажсан байна/;
6. Тухайн лабораторид био-анагаах судлаач, техникч нарт жилд 8-аас доошгүй удаа хичээл заасан байх /сургалтын материал, эмнэлгийн сургалтын албаар баталгаажсан байна/;

7. Мэргэжлийн англи хэлний зохих түвшингийн мэдлэгтэй байх /гэрчилгээгээр баталгаажсан байна/;
8. Компьютерийн мэдлэгийн зохих түвшин хангасан /гэрчилгээгээр баталгаажсан байна/;
9. Сүүлийн 5 жилд өгүүлэл, илтгэлийн 6-аас доошгүй хураангуй нийтлүүлсэн байх /өгүүлэл, илтгэлийн хураангуйн хуулбараар баталгаажсан байна/.



ЛАБОРАТОРИЙН ТЕХНИКЧ

АХЛАХ зэрэг горилогч эмнэлгийн мэргэжилтэн нь дараах тусгай шаардлагыг хангасан байна. Үүнд:

1. Лабораторийн оношилгооны чиглэлээр 8-аас доошгүй жил тасралтгүй тусламж үзүүлсэн туршлагатай байх /нийгмийн даатгалын бичилтээр баталгаажсан байна/;
2. Сүүлийн 5 жилийн ажлын тайлан /удирдах ажилтны тамга, гарын үсгээр баталгаажсан байна/;
3. Жилд мэргэжлийн 3-аас доошгүй кредитийн сургалтанд хамрагдсан байх /гэрчилгээ, тодорхойлолтоор баталгаажсан байна/;
4. Сүүлийн 5 жилд тухайн лабораторид 2-оос доошгүй шинэ арга технологи, ашигтай загвар нэвтрүүлсэн байх /гэрчилгээ, тодорхойлолтоор баталгаажсан байна/;
5. Тухайн лабораторид техникч нарт жилд 3-аас доошгүй удаа хичээл заасан байх /сургалтын материал, эмнэлгийн сургалтын албаар баталгаажсан байна/;
6. Сүүлийн 5 жилд өгүүлэл, илтгэлийн 2-оос доошгүй хураангуй нийтлүүлсэн байх /өгүүлэл, илтгэлийн хураангуйн хуулбараар баталгаажсан байна/.

ТЭРГҮҮЛЭХ зэрэг горилогч эмнэлгийн мэргэжилтэн нь дараах тусгай шаардлагыг хангасан байна. Үүнд:

1. Лабораторийн оношилгооны чиглэлээр 13-аас доошгүй жил тасралтгүй тусламж үзүүлсэн туршлагатай байх /нийгмийн даатгалын бичилтээр баталгаажсан байна/;
2. Ахлах зэрэг хамгаалаад 5 жил тасралтгүй ажилласан байх /мэргэшлийн зэргийн үнэмлэхийн эх хувиар баиалгаажсан байна/;
3. Сүүлийн 5 жилийн ажлын тайлан /удирдах ажилтны тамга, гарын үсгээр баталгаажсан байна/;
4. Жилд мэргэжлийн 3-аас доошгүй кредитийн сургалтанд хамрагдсан байх /гэрчилгээ, тодорхойлолтоор баталгаажсан байна/;
5. Сүүлийн 5 жилд тухайн лабораторид 3-аас доошгүй шинэ арга технологи, ашигтай загвар нэвтрүүлсэн байх /гэрчилгээ, тодорхойлолтоор баталгаажсан байна/.
6. Тухайн лабораторид техникч нарт жилд 5-аас доошгүй удаа хичээл заасан байх /сургалтын материал, эмнэлгийн сургалтын албаар баталгаажсан байна/;
7. Сүүлийн 5 жилд өгүүлэл, илтгэлийн 3-аас доошгүй хураангуй нийтлүүлсэн байх /өгүүлэл, илтгэлийн хураангуйн хуулбараар баталгаажсан байна/.



ЭМНЭЛ ЗҮЙН ЭМГЭГ СУДЛАЛ

АХЛАХ зэрэг горилогч эмнэлгийн мэргэжилтэн нь дараах тусгай шаардлагыг хангасан байна. Үүнд:

1. Лабораторийн оношилгооны чиглэлээр 8-аас доошгүй жил тасралтгүй тусламж үзүүлсэн туршлагатай байх /эмч нарын тойрон үзлэг, зөвлөгөөн, эмгэг анатомийн хуралд оролцож хийсэн мэдээлэл-протоколоор баталгаажсан байна/;
2. Сүүлийн 5 жилийн ажлын тайлан /удирдах ажилтны тамга, гарын үсгээр баталгаажсан байна/;
3. Жилд мэргэжлийн 6-аас доошгүй кредитийн сургалтанд хамрагдсан байх /гэрчилгээ, тодорхойлолтоор баталгаажсан байна/;
4. Сүүлийн 5 жилд тухайн лабораторид 3-аас доошгүй шинэ арга технологи, ашигтай загвар нэвтрүүлсэн байх /гэрчилгээ, тодорхойлолтоор баталгаажсан байна/;
5. Сүүлийн 5 жилд шинжилгээний заавар, удирдамж, стандарт 3-аас доошгүй боловсруулсан байх /боловсруулсан баримт бичгийн хуулбараар баталгаажсан байна/;
6. Сүүлийн 5 жилд мэргэжлийн чиглэлээр тухайн эмнэлгийн эмч нарт 5-аас доошгүй удаа хичээл заасан байх /сургалтын материал, эмнэлгийн сургалтын албаар баталгаажсан байна/;
7. Мэргэжлийн англи хэлний зохих түвшингийн мэдлэгтэй байх /гэрчилгээгээр баталгаажсан байна/;
8. Компьютерийн мэдлэгийн зохих түвшин хангасан байх /гэрчилгээгээр баталгаажсан байна/;
9. Сүүлийн 5 жилд өгүүлэл, илтгэлийн 5-аас доошгүй хураангуй нийтлүүлсэн байх /өгүүлэл, илтгэлийн хураангуйн хуулбараар баталгаажсан байна/;
10. Сүүлийн 5 жилд салбар, байгууллага хөгжүүлэх төсөл боловсруулж хэрэгжүүлсэн байх /холбогдох байгууллагын тодорхойлолтоор баталгаажсан байна/.

ТЭРГҮҮЛЭХ зэрэг горилогч эмнэлгийн мэргэжилтэн нь дараах тусгай шаардлагыг хангасан байна. Үүнд:

1. Лабораторийн оношилгооны чиглэлээр 13-аас доошгүй жил тасралтгүй тусламж үзүүлсэн туршлагатай байх /эмч нарын тойрон үзлэг, зөвлөгөөн, эмгэг анатомийн хуралд оролцож хийсэн мэдээлэл-протоколоор баталгаажсан байна/;
2. Ахлах зэрэг хамгаалаад 5 жил тасралтгүй ажилласан байх /мэргэшлийн зэргийн үнэмлэхийн эх хувиар баталгаажсан байна/;
3. Сүүлийн 5 жилийн ажлын тайлан /удирдах ажилтны тамга, гарын үсгээр баталгаажсан байна/;
4. Жилд мэргэжлийн 6-аас доошгүй кредитийн сургалтанд хамрагдсан байх /гэрчилгээ, тодорхойлолтоор баталгаажсан байна/;

5. Сүүлийн 5 жилд тухайн лабораторид 4-өөс доошгүй шинэ арга технологи, ашигтай загвар нэвтрүүлсэн байх /гэрчилгээ, тодорхойлолтоор баталгаажсан байна/;
6. Сүүлийн 5 жилд шинжилгээний заавар, удирдамж, стандарт 5-аас доошгүй боловсруулсан байх /боловсруулсан баримт бичгийн хуулбараар баталгаажсан байна/;
7. Сүүлийн 5 жилд мэргэжлийн чиглэлээр тухайн эмнэлгийн эмч нарт 10-аас доошгүй удаа хичээл заасан байх /сургалтын материал, эмнэлгийн сургалтын албаар баталгаажсан байна/;
8. Мэргэжлийн англи хэлний зохих түвшингийн мэдлэгтэй байх /гэрчилгээгээр баталгаажсан байна/;
9. Компьютерийн мэдлэгийн зохих түвшин хангасан байх /гэрчилгээгээр баталгаажсан байна/;
10. Сүүлийн 5 жилд өгүүлэл, илтгэлийн 5-аас доошгүй хураангуй нийтлүүлсэн байх /өгүүлэл, илтгэлийн хураангуйн хуулбараар баталгаажсан байна/;
11. Сүүлийн 5 жилд салбар, байгууллагаа хөгжүүлэх төсөл боловсруулж хэрэгжүүлсэн байх /байгууллагын даргын тодорхойлолтоор баталгаажсан байна/.

ЗӨВЛӨХ зэрэг горилогч эмнэлгийн мэргэжилтэн нь дараах тусгай шаардлагыг хангасан байна. Үүнд:

1. Лабораторийн оношилгооны чиглэлээр 18-аас доошгүй жил тасралтгүй тусламж үзүүлсэн туршлагатай байх /эмч нарын тойрон үзлэг, зөвлөгөөн, эмгэг анатомийн хуралд оролцож хийсэн мэдээлэл-протоколоор баталгаажсан байна/;
2. Тэргүүлэх зэрэг хамгаалаад 5 жил тасралтгүй ажилласан байх /мэргэшлийн зэргийн үнэмлэхийн эх хувиар баталгаажсан байна/;
3. Сүүлийн 5 жилийн ажлын тайлан /удирдах ажилтны тамга, гарын үсгээр баталгаажсан байна/;
4. Жилд мэргэжлийн 6-аас доошгүй кредитийн сургалтанд хамрагдсан байх /гэрчилгээ, тодорхойлолтоор баталгаажсан байна/;
5. Сүүлийн 5 жилд тухайн лабораторид 5-аас доошгүй шинэ арга технологи, ашигтай загвар нэвтрүүлсэн байх /гэрчилгээ, тодорхойлолтоор баталгаажсан байна/;
6. Сүүлийн 5 жилд шинжилгээ, мэргэшил арга зүйн чиглэлээр бодлогын баримт бичиг 8-аас доошгүй боловсруулсан байх /боловсруулсан баримт бичгийн хуулбараар баталгаажсан байна/;
7. Сүүлийн 5 жилд мэргэжлийн чиглэлээр тухайн эмнэлгийн эмч нарт 15-аас доошгүй удаа хичээл заасан байх /сургалтын материал, эмнэлгийн сургалтын албаар баталгаажсан байна/;
8. Лабораторийн мэргэжилтэн бэлтгэх сургалтанд сургагч багшаар ажилласан байх /тушаал, үнэмлэх, тайлангаар баталгаажсан байна/;
9. Мэргэжлийн англи хэлний зохих түвшингийн мэдлэгтэй байх /гэрчилгээгээр баталгаажсан байна/;
10. Компьютерийн мэдлэгийн зохих түвшин хангасан байх /гэрчилгээгээр баталгаажсан байна/;
11. Сүүлийн 5 жилд өгүүлэл, илтгэлийн 8-аас доошгүй хураангуй нийтлүүлсэн байх /өгүүлэл, илтгэлийн хураангуйн хуулбараар баталгаажсан байна/;
12. Сүүлийн 5 жилд салбар, байгууллагаа хөгжүүлэх төсөл боловсруулж хэрэгжүүлсэн байх /байгууллагын даргын тодорхойлолтоор баталгаажсан байна/.